

Шинжлэн магадлах ухаан


**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНД
КРИМИНАЛИСТИКИЙН ТЕХНИК ЗҮЙН МЭДЛЭГ АШИГЛАХ НЬ**

**THE PROBLEM OF USING CRIMINALISTICS TECHNICAL KNOWLEDGE
IN THE EXECUTION OF COURT DECISIONS**



Э.Батбаяр

*Дотоод хэргийн их сургууль,
Шинжлэн магадлахуйн институтийн ахлах багш,
магистр, цагдаагийн хошууч*



О.Одонтуяа

*Дотоод хэргийн их сургууль,
Шинжлэн магадлахуйн институтийн эрдэм
шинжилгээний ажилтан-багш, докторант,
цагдаагийн дэд хурандаа*

Товч утга: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд криминалистикийн техник зүйн мэдлэг ашиглах тухай ойлголт, нөхцөл, эрх зүйн зарим зохицуулалт, анхаарах асуудлын талаарх мэдлэгийг хүргэхийг зорьсон.

Түлхүүр үгс: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, хойшлуулшгүй тохиолдол, мөр мөшгөх, криминалистикийн гэрэл зураг, криминалистикийн бүртгэл, криминалистикийн хэл.

Abstract: It is intended to bring together the concepts, conditions, legal regulations, and the issues to be considered regarding the use of forensic technical knowledge in the execution of court decisions.

Keywords: Court order enforcement, case of delay, trace, evidence, criminalistics registration.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, хүний эрх, эрх чөлөөг зөвхөн хуульд зааснаар хязгаарлах, энэрэнгүй, шуурхай байх зарчмыг баримталдаг. Криминалистикийн шинжлэх ухааны мэдлэг нь хүний эрхийг хангах шинжлэх ухааны баталгаа болдог. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд криминалистикийн шинжлэх ухааны мэдлэгийг ашиглах зайлшгүй шаардлага тулгардаг.

Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд криминалистикийн мэдлэгийг ашиглах нь. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар хорих ангийн харьяа нутаг дэвсгэрт хоригдлын үйлдсэн гэмт хэрэгт хорих байгууллагын эрх бүхий албан тушаалтан дараах мөрдөн шалгах ажиллагааг хойшлуулшгүй тохиолдолд явуулж, прокурорт даруй шилжүүлэх үүрэгтэй¹⁵⁸ байдаг. Үүнд:

1. Үзлэг хийх;
2. Шинжилгээнд зориулж дээж, хурууны хээ, ул мөрний хэв авах;
3. Хохирогч, гэрчээс мэдүүлэг авах;
4. Хэрэгт ач холбогдол бүхий тээврийн хэрэгсэл, мөнгө, эд зүйлийг хурааж авах;
5. Эд хөрөнгийг битүүмжлэх;
6. Шинжилгээ хийлгэх шийдвэр гаргах.

Хорих байгууллагын эрх бүхий албан тушаалтан хойшлуулшгүй тохиолдолд л дээрх мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлнэ. Хойшлуулшгүй тохиолдолд дараах нөхцөл байдал багтдаг:

1. Хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой хохирол учрах;
2. Сэжигтэн, яллагдагч оргон зайлах;
3. Хэргийн ул мөр, эд мөрийн баримт устах, зөөвөрлөх, нуун далдлах, үрэгдэх бодит аюул байгаа.

Хорих ангийн харьяа нутаг дэвсгэрт хойшлуулшгүй тохиолдлын 1, 2-т заасанг эрх бүхий албан хаагчид тэр даруй гүйцэтгэж таслан зогсоох, сэргийлдэг. Харин “хэргийн ул мөр, эд мөрийн баримт устах, зөөвөрлөх, нуун далдлах, үрэгдэх бодит аюул байгаа” тохиолдолд хэргийн газрын хамгаалалт болон үзлэгийг бүрэн дүүрэн хийж гүйцэтгэх шаардлага бий болдог.

Хорих ангийн харуул хамгаалалтын журамд¹⁵⁹ “хоригдлын зүгээс үйлдсэн орголт, гэмт хэрэг, зөрчлийг мэдсэн, илрүүлсэн алба хаагч хорих ангийн ерөнхий жижүүрт дариу мэдэгдэнэ, ерөнхий жижүүр нөхцөл байдлыг үнэлэн хойшлуулшгүй арга хэмжээг шуурхай авч, онцгой нөхцөл бий болсон үед ажиллах ерөнхий болон чиглэлийн төлөвлөгөө, оператив жижүүр, шуурхай штабаас өгсөн

¹⁵⁸ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2017 он. № 30.7 зүйл

¹⁵⁹ Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/197 дугаар тушаалын хавсралт.

үүрэг чиглэлийн дагуу дараагийн ажиллагаанд шилжинэ” гэж заасны дагуу хорих ангийн хамгаалалтын ажилтнууд тухайн орон нутгийн цагдаагийн байгууллагад нэн дариу дуудлага мэдээлэл өгч, хэргийн газрын хамгаалалтыг зохион байгуулах үүргийг хүлээдэг.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан “хэргийн ул мөр, эд мөрийн баримт устгах, зөөвөрлөх, нуун далдлах, үрэгдэх бодит аюул байгаа” тохиолдолд “Үзлэг хийх”¹⁶⁰ прокурорт даруй шилжүүлэх үүргээ биелүүлэхээс илүүтэйгээр Хууль зүй, дотоод хэргийн сайдын журмыг баримтлан орон нутгийн цагдаагийн байгууллагад нэн дариу дуудлага мэдээлэл өгч, хэргийн газрын хамгаалалтыг зохион байгуулж байгаа практикт үйл ажиллагаанд түгээмэл байдаг.

Хорих байгууллагын эрх бүхий албан тушаалтан хэргийн газрын орчинд үүссэн ул мөр, эд мөрийн баримтыг цас, бороо, салхи шуурга гэх мэт байгаль цаг уурын нөхцөл болон бусад шалтгааны улмаас устгах нөхцөл байдал үүссэн үед мөр илрүүлж, бэхжүүлэх ажиллагааг хийх онолын мэдлэг болон хэргийн газрын үзлэгийн техник хэрэгслийг ашиглах боломж бүрдсэн, түүнийг ашигладаг байх ёстой.

Хорих ангид үйлдэгддэг гэмт хэргийн онцлог нөхцөл байдлыг харгалзан хэргийн газрын хамгаалалт болон үзлэгийг зөв зохион байгуулах нь хэрэг үйлдэгдсэн байдал, гэмт этгээдийн тухай болон бусад байдлын талаар анхны мэдээлэл цуглуулах, гэмт хэрэгтнийг халуун мөрөөр нь эрэн сурвалжлах, бусад гүйцэтгэх ажлын мэдээ, мэдээллийг олж авах, гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг тогтоох, хэрэгт ач холбогдолтой ул мөр, эд мөрийг устгах, гэмтэхээс сэргийлж нотлох баримт болгох боломжийг бүрдүүлэх ач холбогдолтой.

Хорих ангид үйлдэгдсэн гэмт хэргийн газар түрүүлж ирсэн алба хаагч /ахлагч, офицер/ хэргийн газарт үүссэн ул мөрийг гэмтээхгүй, устгахгүй байх, мөн өөрсдийн ул мөрийг нэмэлтээр үлдээхгүй байх тал дээр сайтар анхаарах шаардлагатай.

Хэргийн газар, мөрний талаар мэдээлэл багатайгаас мөрийг санаандгүй устгах, гэмтээх эрсдэл байдаг.

Хойшлуулшгүй ажиллагааны хүрээнд үзлэг хийхэд криминалистикийн мөр судлалын мэдлэг түүний дотор мөртэй ажиллах зарчим, мөр цуглуулах (илрүүлэх, бэхжүүлэх, битүүмжлэх, хадгалах) болон хэргийн газрын орчин нөхцөлийг бодитойгоор дүрслэн, харуулахын тулд криминалистикийн гэрэл зургийн арга барилыг ашиглах шаардлага зүй ёсоор тулгардаг.

¹⁶⁰ Үзлэгийн төрөлд хэргийн газрын үзлэг, цогцосны үзлэг, хүний биед, эд зүйлд гэх мэт үзлэг хамаардаг.

Мөн гэмт этгээд оргон зугтсан хэргийн газар криминалистикийн мөр мөшгөх аргыг тогтсон аргачлалын дагуу явуулах нь чухал үр нөлөөтэй. Түүнчлэн мөр мөшгөхөд хөлийн мөр болон үнэрийн мөрийг ашигладаг. Хөлийн мөрөнд агуулагдаж байгаа шинж тэмдэг, шинж чанарыг ашиглан мөрийг мөшгөнө. Мөн хөлийн мөр үүссэн цаг хугацаа, үүссэн зүй тогтол, хүлээн авагч объектын онцлог зэрэг шинж чанарыг анхаарна. Хөлийн мөр мөшгөхдөө гутлын мөрийн нийт урт, өсгийн өргөн, өлмийн өргөн, түүнд агуулагдаж буй дахин давтагдашгүй хувийн онцлог шинж тэмдгийг тогтоох, түүнийг гар зураг болон гэрэл зургаар бэхжүүлнэ. Ингэснээр мөрийг мөшгөх явцад мөр бүдгэрэх, ижил төрлийн хөлийн мөрийн хээ зураглалтай холилдох үед ялган таних боломжийг криминалистикийн мөр судлалын мэдлэг олгоно. Мөрийг мөшгөхөд ач холбогдолтой нэг мөр нь үнэрийн мөр юм. Үнэрийг мөрийг илрүүлэхэд тулд үнэрч нохой, мэргэжилтэн /нохой хөтлөгч/ байх шаардлагатай байдаг.

Дараагийн чухал ажиллагаа бол криминалистикийн гэрэл зураг бөгөөд дараах байдлаар ашигладаг. Үүнд:

1. Гэмт хэрэг үйлдэгдсэн орчин, нөхцөл, ул мөр, эд мөрийн баримтын харилцан байрлал, шинж чанар, шинж тэмдэг зэргийг бэхжүүлэх;
2. Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны явц, үр дүнг баримтжуулах /эд хөрөнгө битүүмжлэх ажиллагаа гэх мэт/;
3. Хоригдлыг таниулах гэрэл зураг /нүүр, содон шинж тэмдэг гэх мэт/;
4. Хорих ангийн дотоод журам зөрчсөн үйл явцыг баримтжуулах.

Мөн криминалистикийн бүртгэлийн мэдлэгийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ял эдэлж байгаа хоригдогч, хоригдол, ялтны гэрэл зураг, гарын хээ болон бусад мэдээллийг төрөл бүрийн санд бүрдүүлэх ашиглан хөтөлдөг. Мөн криминалистикийн бүртгэлийн шуурхай лавлагааны тоо бүртгэл, туслах лавлагааны тоо бүртгэлийг түгээмэл ашиглаж болно. Жишээлбэл “Гэмт хэрэгтний фото, видео дүрсийн сан”-г бүрдүүлэхэд ашиглана.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд криминалистикийн мэдлэгийг ашиглахын тулд мэргэжилтний мэдлэг, ур чадвараас гадна хэргийн газрын үзлэг хийхэд тусгай зориулалтын техник хэрэгсэл бүхий иж бүрэн цүнхийг хорих ангийн жижүүрийн шуурхай албанд байлгах шаардлагатайг анхаарах зүйтэй.

Хууль зүй, дотоод хэргийн Сайдын 2009 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 110 дугаар тушаалаар баталсан журмаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хоригдогч, хоригдол, ялтны гэрэл зураг, гарын хээний бүртгэлийг хөтлөх үүргийг хүлээсэн боловч ялангуяа гарын хээний бүртгэлийг хөтөлж байгаа

өнөөгийн байдлын хэрэгжилт хангалтгүй байна гэж үзэж болохоор байна.¹⁶¹ Гарын хээний санд гарын дардас авч бүртгэх, гарын хээний санг зориулалтын дагуу үйл ажиллагаандаа хэрэглэх албан хаагчийг ДХИС-ийн Шинжлэн магадлахуйн институтэд бэлтгэх бүрэн боломжтой юм.

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд криминалистикийн мэдлэгийг ашиглах нь. Тус ажиллагааны хэрэгжилтийг хангахад “Шийдвэр гүйцэтгэлийн хувийн хэрэг” хөтлөх, баримт бичгийн бүрдлийг баталгаажуулахад шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэр, тэмдэглэл (бичгийн машин, компьютер, эсхүл гар бичмэл, гарын үсэг зурж, албадлагын арга хэмжээний үйл явц, үр дүнг дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлэх) дээрх мэдээллийн үнэн, зөвийг шалгах шаардлага гарах үед криминалистикийн бичиг судлал, бичиг техник судлалын мэдлэг ашигласан үед ямар нэгэн зөрчилдөөн бий болох үед нотломж болох ач холбогдолтой.

Мөн эд хөрөнгө битүүмжлэх, хураан авах ажиллагааг тэмдэглэлээс гадна гэрэл зургийн арга, дүрс бичлэгийг аргаар давхар бэхжүүлэх нь тухайн цаг хугацаанд байсан эд хөрөнгийн гадаад бүтцийн шинж чанар, шинж байдалд болон тодорхой хугацааны дараа эд зүйлд гарсан гадаад бүтцэд гарсан өөрчлөлт, тоо, ширхэг, чанар зэргийн талаарх мэдээллийг баримтжуулахад дэмжлэг үзүүлдэг.

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд эд зүйлс, түүний бүрдэл хэсгүүдийг нэрлэхэд оноосон нэрийг зөв хэрэглэхэд хүндрэл учирдаг. Эртний эдлэл, мал аж ахуйн тоног, автомашин, бусад техник хэрэгсэл гэх мэтийг нэрлэхэд криминалистикийн хэл, нэр томъёог ашиглах шаардлага гардаг. Тухайлбал, шинжлэн магадлахуйн эрдэмтэд болох А.Доржготов, Ч.Сонгино нарын “Зурагт толь” бүтээлд бүх төрлийн эд зүйлс, тэдгээрийн бүрдэл хэсгүүдийг нарийвчлан нэрлэсэнийг ашиглаж болно.

Дүгнэлт, санал:

Криминалистикийн мэдлэгийг эрүүгийн болон иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд бүрэн, оновчтой ашигласнаар хорих байгууллагад үйлдэгдсэн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, мөн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хойшлуулшгүй ажиллагааны хүрээнд үзлэг хийхэд мөр судлал, мөртэй цуглуулах ажиллагааг хэрэгжүүлэх, мөр мөшгөх, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны явц, үр дүнг баримтжуулахад

¹⁶¹ Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд Цагдан хорих 461 дүгээр хаалттай анги, Нэгдсэн эмнэлэг 401 дүгээр хаалттай ангид гарын хээний бүртгэлийн “Живой-сканнер” ажлын станцыг суурилуулан ашиглалтад оруулсан хэдий ч 2020 онд бэлтгэгдсэн ажлын хэсгийн оператор ажлаас чөлөөлөгдснөөр уг станцыг ажиллуулах, гарын хээний тоо бүртгэлийг хөтлөөгүй байна.

криминалистикийн гэрэл зураг, дүрс бичлэг ашиглах, хоригдогч, хоригдол, ялтны бүртгэл, мэдээллийг сан, бүртгэл бүрдүүлэхэд криминалистикийн бүртгэл ашиглах, шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд эд зүйлс, түүний бүрдэл хэсгүүдийг зөв оноон нэрлэх зэргээр өргөн ашиглах боломжтой.

Иймээс шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдын криминалистикийн мэдлэгийг дээшлүүлэхэд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдад хэргийн газрын хамгаалалт, үзлэгийн чиглэлийн дадлага сургалтыг зохион байгуулах,

- Мөн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд криминалистикийн мөр судлал, бичиг судлал, бичиг-техник судлал, үнэр судлал болон бүртгэлийн талаарх мэдлэг, чадварыг олгох давтан сургалтыг зохион байгуулах;

- Хорих ангид хэргийн газрын хамгаалалт, үзлэг зохион байгуулах чиглэлээр “Дадлага сургалт”-ыг харьяа орон нутгийн цагдаа, шүүх шинжилгээний байгууллагатай хамтран зохион байгуулах;

- Хорих ангийн жижүүрийн техник хэрэгслийн нөөцөд хэргийн газрын үзлэгийн цүнхийг нэмж оруулах.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

1. Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 1992 он, №1
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2017 он, №24
3. Шүүх шинжилгээний тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2023 он, №05
4. Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2017 он, №23
5. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2002, №8.
6. “Хорих ангийн харуул хамгаалалтын журам”. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/197 дугаар тушаалын хавсралт
7. “Гарын хээний нэгдсэн сангийн журам”. Хууль зүй, дотоод хэргийн Сайдын 2009 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 110 дугаар тушаалын хавсралт
8. Б.Баяр нар., Хамтын бүтээл “Гэмт хэрэг илрүүлэхүй”. Уб., 2015 он
9. Б.Жаргалсайхан., “Учралын газрын үзлэг”. Уб., 2008 он
10. Б.Лхагвасүрэн., “Мөр”. Уб., 2015 он
11. Ч.Батболд., “Хорих ангид үйлдэгдсэн гэмт хэрэгт хэргийн газрын үзлэг зохион байгуулахад анхаарах асуудал” сэдэвт илтгэл. “Хүний эрх ба Шинжлэн магадлах ухаан” ОУЭШХ-ын илтгэлийн эмхэтгэл. Уб., 2022 он

12. Б.Замбага., “Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувийн хэрэг талуудын эрхийг хангах нотлох баримт болох нь” сэдэвт илтгэл. “Хүний эрх ба Шинжлэн магадлах ухаан” сэдэвт ОУЭШХ-ын илтгэлийн эмхэтгэл. Уб., 2022 он

13. Г.Хосбаяр., “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад криминалистикийн бүртгэлийг ашиглаж буй өнөөгийн байдал, цаашид анхаарах асуудал” сэдэвт илтгэл. “Хүний эрх ба Шинжлэн магадлах ухаан” сэдэвт ОУЭШХ-ын илтгэлийн эмхэтгэл. Уб., 2022 он

---o0o---